Buddha's Wisdom Changes Your Life
SHANZAI
2011 9
Volume 72
Rissho Kosei-kai

## The World of the Lotus Sutra

Цагаан Лянхуа Цэцгийн Судар
**–Эмийн ургамалтай харьцуулсан 5-р бүлэг**

Дөрвөн Агуу Их Шёмон нар Шагжамүнигийн айлдсан үлгэрийн жишээний ачаар Буддагийн агуу их нигүүлсэхүйг мэдэрч, "итгэл" ба "ойлголт"-ыг ойлгосон гэдгээ мэдэгдэв.Үүнд Шагжамүни нь ийнхүү өгүүлсэн байна:

"Махакашьяпа,чиний зөв.Чи Буддагийн Язгуурын Үнэнийг сайвтар гэгээрсэн байна.Гэсэн ч Буддад бол ярьж барагдахгүй маш их ач буян бий.Будда бол сургаалийн хаан мөн.Тийм учраас ямар ч зүйлийн жинхэнэ мөн чанарыг нь гүйцэд мэдэж байдаг юм.Будда бол бүх юмны ялгааг мэдэж,харилцах хүн,газар,нөхцөл байдалд тааруулж сургаалаа айлддаг.Тэрхүү сургаал нь бүх хүмүүсийг Буддагийн гэгээрэлд хүргэдэг.Мөн Будда нь бүх зүйлийн ялгаа ба эрх тэгш чанарыг мэддэг тул үүнийг ард түмэнд дамжуулан зааж байдаг юм."

Ийнхүү өгүүлээд тэрээр эмийн ургамалын харьцуулалтын жишээгээр Буддагийн сургаал ба сургаалыг хүлээн авдаг ард түмний харилцааны тухай бүр дэлгэрэнгүй ярьжээ:

"Манай дэлхийд төрөл бүрийн мод ургадаг. Хэмжээ нь том,дунд,жижиг гээд л,тус бүрдээ чанар,байдал,хэлбэрээрээ өөр өөр байдаг билээ.Мөн их тэнгэрийн үүлнүүд бүх модон дээгүүр эрх тэгш бороогоо дусгадаг.Их тэнгэрийн бороо орсны ачаар бүх моднууд өөр өөрийн онцлог байдлаар ургаж цэцэглэнэ.Адилхан бороо орсон ч мод бүрийн төрөл өөр учраас цэцэглэх цэцэг,жимс,наслах нас нь хүртэл өөр өөр байдаг байна.Будда бол их тэнгэрийн том үүл бөгөөд түүний айлддаг сургаал бол газарт урсдаг бороо юм.Ард түмэн бол том,дунд,жижиг модтой адил мод юм.Будда бол бүх хүмүүс мөн чанарынхаа хувьд эрх тэгш бөгөөд Язгуурын Үнэний ачаар бүгд эрх тэгш аврагддаг гэдгийг мэддэг боловч хүмүүсийн сэтгэлийн байдал,шунал хүсэл нь өөр өөр байдаг тул тэрхүү ялгаанд нь тааруулж янз бүрийн аргаар сургаалаа айлддаг байна.Энэ нь тухайн хүнийг үнэхээр аварч чадах арга учраас тэрээр хүнд шууд Язгуурын Оюун Ухааны тухай тайлбарлахыг боддоггүй.Та бүгд бол хэр бараг байдаггүй мундаг ухаантай хүмүүс.Яагаад гэвэл та нар бүх будда нарын тухайн газарт тааруулсан сургаалын утга учрыг сайвтар ойлгож, үндсэн мөн чанарыг нь хүртэл ойлгон мэдэрсэн юм.Энэ бол маш хэцүү зүйл юм".

Мөн эцэст нь:"Үнэнийг хэлэхэд,Шёмон та бүгд одоохондоо бүх эргэлзээгээ хаясан байгаа гэж хэлж чадахгүй.Гэвч та бүгдийн даяан бол тэр чигээрээ бодисадвагийн замтай нийлж байгаа билээ.Даянаа сайвтар хийж байвал заавал Будда болно"гэж урамшуулан хэлжээ.



# Нас ахих

РКК-ийн Ерөнхийлөгч
**Нивано Ничико**

## Өтлөх гэдэг нь

Та бүгдийн мэдэж байгаагаар ханз үсэг бүрт өөрийн гэсэн утга байдаг. Жишээлбэл, 9 –р сарын "Ахмад хөгшдийг хүндлэх өдөр"-ийн ханзыг авч үзэхэд "хөгшин"гэсэн үсэг нь далаас дээш насны хүнийг заадаг билээ. Энэ ханзанд бас жаран нас гэсэн ч бий. Аль аль нь ч хөгшрөх гэсэн утгатай боловч үгийн утгыг ийнхүү задлан аваад үзэхэд үл тоодоггүй байсан зүйлийг бие сэтгэлээрээ анзаарч,"би ч бас хөгширч байна даа"гэж мэдрэх болов уу.

Шагжамуни нь "та зүгээр л нас нэмэж хөгширсөн бол "хоосон зөнсөн хөгшин"болно.Харин бусдыг энэрэн өрөвдөх буянтай сэтгэлтэй болсон бол "нигүүлсэхүй сэтгэлтэй,буянтай ахмад хүн" гэж дуудагдах болно"гэж заасан билээ.

Шагжамуни бас ийнхүү нэг ширүүн үг үлдээсэн билээ:"Юм сурдаггүй хүн үхэр шиг өтлөнө.Мах нь нэмэгдсэн ч оюун ухаан нь хэзээ ч нэмэгдэхгүй".Азийн гүн ухаантан Ясүока Масама багш нь хөгшрөлтийн талаар ингэж хэлсэн байдаг:"Хүн хөгшрөнө гэдэг бол туршлага сууж,оюун ухаанаа гүнзгийрүүлж,амьдралаа бүрэн гүйцэд болгох "чармайлтын үйл явцас"бөгөөд үүний төлөө байнга суралцаж,бүрэн хөгжилтийг зорьдог юм".

Хичнээн нас ахисан ч их зан гаргалгүй өөрийгөө ямагт дээшлүүлэн хөгжүүлэхийг зорьж,өдий хүртэл хураасан оюун ухаанаа хүний төлөө зарцуулж байх нь "хөгшрөлт" – ийн мөн чанар юм.



## Нас нэмнэ гэдэг бол баярлах зүйл

Хичнээн тэгж бодсон ч ихэнх хүмүүс хөгшрөх явдлыг хүлээн зөвшөөрч чаддаггүй.

Шагжамүни будда “Цаг хугацаа өнгөрч, өдөр шөнө солигдохын хэрээр залуу цагийн гоо үзэсгэлэн биднийг орхиж одно” гэсэн хатуу хэрнээ үнэн үгийг үлдээсэн байдаг. Энэ нь бидэнд “Төрөх, өтлөх, өвдөх, үхэх гэсэн ертөнцийн үнэн мөн чанарыг сайтар ойлгогтун хэмээсэн сургамж юм. Түүнийг ойлгож гэмээнэ хөгшрөлт хийгээд үхлээс айхгүй, өдөр бүрийнхээ амьдралаа сэтгэл дүүрэн өнгөрөөж чадна” хэмээн бурхан багш нигүүлсэхүйн сэтгэлээр сургасан байдаг.

Киотогийн их сургуулийн захирал асан Хирасава Коо гуай “Төрөх, өтлөх, өвдөх, үхэх”-ийн дөрвөн зовлонг “Дөрвөн баясгалан” гэж хүлээн авсан байдаг. Тэрээр жилд дөрвөн улирал байдаг шиг хүний амьдралд төрөх, өтлөх, өвдөх, үхэх гэж байдаг нь сонирхолтой бөгөөд тус бүрдээ өөрийн гэсэн баяр баясгалантай байдаг гэж хэлсэн билээ.

Тэрээр мөн үхлийн тухай ингэж хэлсэн байдаг. “Байгаль эхээс заяагдсан амь эргээд байгал дэлхийдээ шингэнэ. Байгаль эхийн нэгэн хэсэг болж уусаад дахиад байгалыг бүтээх эргэлтэнд ордог. Тэр утгаараа үхэл гэдэг нь алга болно гэсэн үг бус харин ч байгаль эхийг бүтээлцэхэд оролцож байгаа явдал юм” хэмээн өгүүлсэн байдаг.

Өтлөх хийгээд үхэх нь бурхан багшийн нигүүлсэхүй хэмээн хүлээн авч чадвал өтлөхийн жинхэнэ утгыг ухаарахын зэрэгцээ баяр баясгаланг мэдэрч чадна.

Жишээлбэл: залуу байхдаа хүнд хэлмээр байвч яаж хэлэх аргаа мэддэггүй байсан зүйлээ нас ахиад ирэхээрээ ахмад хүний ухаанаар аргыг нь олоод хэлчихдэг болдог. Тийм ч утгаараа сурч мэдсэн зүйлсээ дараа үеийнхэндээ дамжуулаад явах нь ахмад хүний үүрэг гэж хэлж болох юм.

Ер нь тэгээд хүн болж төрсний баяр баясгалан, амь насны эрхэм чанар, амьдрахын баяр хөөр гэхчлэн хүний амьдралын чухал зүйлсийг хойч үеийнхэндээ дамжуулж заана гэдэг бол жинхэнэ нигүүлсэхүйн сэтгэл юм. Түүнчлэн энэ нь нас нэмж, бие махбодийн хувьд санаан зоргоор хөдөлж чадахгүй болсон ч үг, хэлээрээ хэрэгжүүлж чадах бодисадвагийн үйл юм.

Нас ахиж гэмээнэ л олж чадах ухаан гэж байдаг. Тэр ухааныг олохын төлөөх урагш тэмүүлсэн сэтгэл, өөдрөг байдал нь хүний амьдралын утга учир, баяр баяслын эх ундрага болох нь гарцаагүй.

“Косэй”2011 оны 9 сарын дугаараас
Translated by Kosei Publishing Company



# Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч Нивано Коошо багш

## Эхлээд үүлэрч дараа нь цэлмэрдэг -- Дөрвөн эгч дүүс

“Хүүе ээ,одоо миний ээлж ш дээ”
“Жаахан хүлээж бай”
“Байз л даа”,”Ямар зальтай юм бэ”—дөнгөж сая хүртэл найрсаг тоглож байсан хүүхдүүд маань тэнгэр бүрхэгдэж байгаа мэт гэнэт муудалдаж эхлэв.

“Манайх гайтай юм шиг дандаа дөрвүүлээ бие биенээ хүлээж,ээлжээр юмаа хэрэглэх ёстой”,”Найзын гэрт хүн бүрт нэг нэгээр нь өгдөг байхад”,”Бас тэгээд дүү нар ерөөс үгэнд орохгүй шүү”,”Эгч гуай дандаа хүн загинаад байдаг”гэх мэтээр ам амандаа үглээд хүүхдүүд ууртай гэгчээр над уруу давшлан гүйж ирнэ.”Яасан бэ?”гэж асуухад хүүхэд бүр нөгөөдхөө муулж,өөрөө хичнээн зовж зүдэрч байгаагаа ам амандаа уралдан ярьж тайлбарлана.

“Айлын ганц хүүхэд байсан бол хичнээн амар байхгүй юу.Бүх юмыг өөрөө ээзлж авчихаад л ёстой сайхан”,”Чихэр боовоо ч хүнтэй хуваалцах хэрэггүй”,”дүүгээ ч харах хэрэггүй”,”ер нь тэгээд дөрвөн хүүхэд гэдэг чинь дэндүү олон юм аа”,”Тийм,тийм,ёстой зөв”,”Нээрэй шүү,ээж та юу гэж бодож байна?”гэж хүүхдүүд маань нөгөө маргалдсан шалтгаанаа ч мартсан бололтой надаас тулж асуухад “Юу гэнэ ээ?” гэж би гайхав.Хүүхдүүд намайг тэднийг зэмлэх байх гэж бодсон бололтой ээж нь ч бас санал нийлж байна гэж хариулахад ихэд гайхсан шинжтэй байв.

“Ээж нь ч гэсэн дөрвөн дөрвөн хүүхдийн хувцас хунарыг нь угааж хатаах,индүүдэж ивхэх гэж их л яршигтай байдаг шүү.Бас тэгээд дуу чимээ гэж байнга хашгирч,маргалдаж,гадагшаа дагуулж гарахад ч хүртэл хэцүү шүү.Нээрэй дэндүү олон хүүхэдтэй.Та бүгд хэдүүлээ байсан бол зөв гэж бодож байна?”гэж тэд нараас асуухад:”Ганцаараа байсан бол гоё”,”Үгүй ээ,ганцаараа уйтгартай тул хоёюулаа байвал гоё”,”Тийм,тийм,хоёр эгч дүү байвал яг таарна.Хоёюулаа ээжийн хажууд унтаж чадна шүү дээ”гээд хөөрөн ярьцгааж байв.

“Ээж,та ч гэсэн хоёрхон л хүүхэдтэй байсан бол ёстой амар

**Нивано Коошо**

Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн. Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.



байхгүй юу,тээ?”,”Ер нь хоёр л хүүхэд байсан бол таарах байсан юм”гээд бүгд санал нийлсэн бололтой байв.Тэгэхлээр нь тэд нараас эргээд ингэж асуув:”Хоёр л хүүхэд гэхлээр энд хэнийг хасах вэ?”

“За,байз...”,”.....”гээд бүгд дуугаа хураан бодож эхлэв.Хэсэг хугацаа бодсоны дараа тэр дөрөв бие биенийхээ царайг харцгаав.Тэгээд том охин маань:”Би ерөөсөө дөрвүүлээ л байхыг хүсэж байна.Хэрэггүй хүүхэд гэж хэн ч байхгүй учраас”,”Би ч гэсэн”,”Би ч гэсэн”,”Би бас”,”Ээж нь ч бас тэгж бодож байна”гээд бүгд бие биенээ харан инээмсэглэв.Дургүй хүрэх үе,яршигтай үе,уур хүрсэн тохиол ч их байдаг боловч хэрэггүй хүүхэд гэж ганц ч байхгүй гэдгийг чин сэтгэлээсээ мэдэрсэн билээ.”Бүгдээрэнд нь хайртай”,”Ээж нь ч та бүгдэд маш их хайртай”гээд дөрвөн хүүхдээ дөрвүүлэнгийг нь тэвэрсэн юм.

Дөрвүүлээ бие биенээ тэвэрч ээждээ наалдан тэврүүлж байхыг нь сайн харахад хамгийн жаахан дүүгээ шахахгүйн тулд урдаа гарган тэвэрч,бүгд бие биендээ хүрэхийн тулд эвтэйхэн тэврэлдцэнэ байв.

“Якүшин” 2010 оны 7 сарын дугаараас Translated by Kosei Publishing Company

Үүсгэн байгуулагч Нивано Никкё-гийн сургаал

# Будда болох боловсрол

Боловсролын зорилго бол хүнд зөвхөн мэдлэг олгохоос гадна бас хүнийг сайн хүн болгоход оршдог байна.Хүнийг бүрэн гүйцэд боловсруулан хөгжүүлэх нь боловсролын жинхэнэ зорилго юм.

Хүний бүрэн хөгжилт нь дан мэдлэгээр бүрддэггүй юм.Үүнд шашны боловсрол ба мэдээлэл дагалдах ёстой боловч одоогийн боловсролын ертөнцөд энэ асуудал нь үл тооцогддог байна.

Хүний бүрэн гүйцэд хөгжилт гэдэг нь буддын сургаалын үгээр тайлбарлавал “Будда болох”явдал билээ.Хүн бол уг үндсэндээ ганцаар тогтнож чаддаггүй амьтан юм.Хүнтэй нийлж нийгэм бүтээж,хамтдаа амьдардаг жам ёстой билээ.Тийм ч учраас нийгмийн сурган хүмүүжлийн талаар сайвтар зааж сургах нь зүйтэй юм.Юуны өмнө өөрийн юм ба хүний юмны ялгааг мэдэх хэрэгтэй.Дараагаар нь өөрийнхөө хүч чадлаар өндийж босож сурах хэрэгтэй.Унасан ч өөрөө босох шаардлагатай.Мөн хүн гэдэг амьтан бол ясан ч ганцаар амьдарч тогтнож чадахгүй учраас бусдыг бодож сурах хэрэгтэй.

Энэ бүгдийг шашны сургаал заадаг юм.Хичнээн мундаг Их дээд сургууль төгссөн ч хувиа хичээж,өөрийгөө л боддог тул бусдаас ад үзэгддэг хүн ч байдаг.Иймдээ хүрвэл Их дээд сургууль явсны ямар ч хэрэгцээ байхгүй болно. Ийнхүү шашны боловсрол бол өнөө үед үнэхээр хэрэгцээтэй зүйл болж байгаа билээ.

Үүсгэн Байгуулагчийн Үг 5 (Kosei Publishing Co.), 280-281x

## Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганүма Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашны нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайвныг зорьдог юм.





SHAN-ZAI Volume 72 (September 2011)

[Эрхлэн гаргач] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв.
**Хаяг:** Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan, **TEL:** 03-5341-1124 FAX: 03-5341-1224, **E-mail :** shanzai@kosei- kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

Rissho Kosei-kai

# Overseas Dharma Centers 2011

## Rissho Kosei-kai International
5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
*Tel:* 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

### Rissho Kosei-kai International of North America (RKINA)
4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
*Tel:* 1-949-336-4430 *Fax:* 1-949-336-4432
*e-mail:* info@rkina.org http://www.buddhistcenter-rkina.org

### Branch under RKINA
**Rissho Kosei-kai of Tampa Bay**
2470 Nursery Rd.Clearwater, FL 33764, USA
*Tel*: (727) 560-2927
*e-mail*: rktampabay@yahoo.com
http://www.rkina.org/tampabay

### Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
*Tel*: 66-2-716-8141 *Fax*: 66-2-716-8218
*e-mail*: thairissho@csloxinfo.com

### Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii
2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
*Tel:* 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
*e-mail:* info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

**Rissho Kosei-kai Maui Dharma Center**
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
*Tel:* 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4265

**Rissho Kosei-kai Kona Dharma Center**
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96750, U.S.A.
*Tel:* 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

### Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles
2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
*Tel:* 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
*e-mail:* rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

**Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio**
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
*Tel:* 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
*e-mail:* dharmasanantonio@gmail.com

**Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**

**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**

### Rissho Kosei-kai of San Francisco
1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
*Tel:* 1-650-359-6951 *Fax:* 1-650-359-5569
*e-mail:* rkksf@sbcglobal.net

**Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center**
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
*Tel:* 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
*e-mail:* rkseattle@juno.com

**Rissho Kosei-kai of Sacramento**

**Rissho Kosei-kai of San Jose**

**Rissho Kosei-kai of Vancouver**

**Lotus Buddhist Circle**
851 N. San mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

### Rissho Kosei-kai of New York
320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
*Tel:* 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
*e-mail:* koseiny@aol.com

**Rissho Kosei-kai of Chicago**
1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
*Tel & Fax:* 1-847-394-0809
*e-mail:* murakami4838@aol.com

### Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma
2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
*Tel & Fax:* 1-405-943-5030
*e-mail:* ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

**Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls**
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
*Tel:* 1-541-810-8127

**Rissho Kosei-kai, Dharma Center of Denver**
4340 E Kentucky Ave #345 Glendale, CO 80234, U.S.A.
*Tel:* 1-303-319-2765 *Fax:* 1-720-876-4534

**Rissho Kosei-kai Dharma Center of Dayton**
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A

### Risho Kossei-kai do Brasil
Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
*Tel:* 55-11-5549-4446 *Fax:* 55-11-5549-4304
*e-mail:* hiromi_mat@yahoo.com http://www.rkk.org.br

**Risho Kossei-kai de Mogi das Cruzes**
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
*Tel:* 55-11-4724-8862

### Rissho Kosei-kai of Taipei
4F, No. 10 Hengyang Road, Jhongjheng District, Taipei City 100
*Tel:* 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433

**Rissho Kosei-kai of Taichung**
No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
*Tel:* 886-4-2215-4832/886-4-2215-4937 *Fax:* 886-4-2215-0647

**Rissho Kosei-kai of Jilung**

### Rissho Kosei-kai of Tainan
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
*Tel:* 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

**Rissho Kosei-kai of Pingtung**
No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
*Tel:* 886-8-732-1241 *Fax:* 886-8-733-8037

### Korean Rissho Kosei-kai
423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
*Tel:* 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
*e-mail:* krkk1125@hotmail.com

**Korean Rissho Kosei-kai of Pusan**
1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
*Tel:* 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

**Korean Rissho Kosei-kai of Masan**

### Branches under the Headquarters
**Rissho Kosei-kai of Hong Kong**
Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic of China
*Tel:* 852-2-369-1836 *Fax:* 852-2-368-3730

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**
39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
*Tel & Fax:* 976-11-318667
*e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sukhbaatar**
18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

**Rissho Kosei-kai of Sakhalin**
1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, Russian Federation
*Tel & Fax:* 7-4242-43-78-56

**Rissho Kosei-kai (Geneva)**
1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
*Tel:* 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
*e-mail:* rkkgva@wcc-coe.org

**Rissho Kosei-kai of the UK**

**Rissho Kosei-kai of Venezia**
Castello-2229 30122-Venezia Ve Italy
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Paris**
86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Sydney**

## International Buddhist Congregation (IBC)
5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibc-rk.org/

# Rissho Kosei-kai of South Asia Division
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

## Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
*e-mail:* thairissho@csloxinfo.com

## Rissho Kosei-kai of Bangladesh
85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
*Tel & Fax:* 880-31-2850238

**Rissho Kosei-kai of Dhaka**
House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
*Tel:* 880-2-8316887

**Rissho Kosei-kai of Mayani**
Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**
Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**
Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**
Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**
Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**
Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**
West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**
Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

## Rissho Kosei-kai of Sri Lanka
382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
*Tel:* 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**
No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

**Rissho Kosei-kai of Habarana**
151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Galle**
No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**
12 Station Road, Kapugastota, Sri Lanka

## Branches under the South Asia Division

**Delhi Dharma Center**
B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
*e-mail:* sakusena@hotmail.com

**Rissho Kosei-kai of West Delhi**
A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

**Rissho Kosei-kai of Kolkata**
E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**
Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
*e-mail:* nrkk@wlink.com.np

**Rissho Kosei-kai of Lumbini**
Shantiban, Lumbini, Nepal

**Rissho Kosei-kai of Singapore**

## Other Groups

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**
1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China